## УРГАЦ ХУРААЛТ, ХАДЛАН ТЭЖЭЭЛ БЭЛТГЭЛИЙН 20.. ОНЫ .. САРЫН ЯВЦЫН МЭДЭЭ (А-ХАА-8)-НИЙ МАЯГТ НӨХӨХ ЗААВАР

Энэхүү маягтыг тухайн жилд газар тариалангийн үйл ажиллагаа эрхэлж, тариалалт хийсэн, өвс, хадлан бэлтгэсэн өрх болон өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагаас тогтоосон хугацаанд нөхөж авна.

**I.ХАЯГИЙН ХЭСЭГ**

**1.Байршил:** Газар тариалангийн үйл ажиллагаа эрхэлсэн аж ахуйн нэгж, байгууллага, өрхийн харьяалагдах аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нэр, кодыг маягтын зааварт тусгасан засаг захиргааны нэгжийн кодоос харж нөхнө.

**2.Аж ахуйн нэгж, байгууллагын мэдээлэл:** Тухайн аж ахуйн нэгж, байгууллагад УБЕГ-аас олгосон регистрийн дугаарыг бичнэ. Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын нэр, холбоо барих утасны дугаарыг бичнэ.

**3.Өрхийн мэдээлэл:** Өрхийн бүртгэлийн дэвтрийн дугаар. Тухайн өрхөд харьяалах баг, хорооноос олгосон 13 оронтой "Өрхийн бүртгэлийн дэвтрийн дугаар"-ыг бичнэ. Тухайн өрхийн тэргүүлэгчийн овог, нэр, холбоо барих утасны дугаарыг бичнэ.

**II. УРГАЦ ХУРААЛТ**

**1. Үр тариа, төмс:** Үр тариа, төмсний хэмжээг хураасан талбай, усалгаатай талбайгаас, нийт хураасан ургац, хорогдол, усалгаатай талбайгаас гэсэн ангиллаар маягтын 1-9 дүгээр мөрөнд өгөгдсөн нэр төрлөөр ялган, нөхнө.

**1 дүгээр баганад** хураасан нийт талбайн хэмжээг асууж нөхнө.Тариалсан талбайгаас ургацыг хураасан талбайн хэмжээ юм. Хураасан талбай нь тариалсан талбайн дүнгээс бага буюу тэнцүү байна. Зөрүү нь ургац алдсан талбай байна.

**2 дугаар баганад** хураасан нийт талбайгаас усалгаатай талбайн хэмжээг сугалж нөхнө. ***(Багана1≥багана2)***

**3 дугаар баганад** нийт талбайгаас хураасан ургацын хэмжээг нөхнө. ***(Багана3=багана(4:5))***

**4 дүгээр баганад** ургац хураалтын үеийн хорогдлын дүнг нөхнө. Ургац хураалтын үеийн хорогдол гэж хураасан ургацыг үтрэмд цэвэрлэсний дараа стандартын шаардлага хангахгүй, цаашид ашиглалтад нийцэхгүй болсон мөн үтрэмээс агуулахруу тээвэрлэх үеийн хорогдлыг хамруулна. ***(Багана3>багана4)***

**5 дугаар баганад** усалгаатай талбайгаас хураасан ургацыг асууж, нөхнө. Ургамлын гарцыг нэмэгдүүлэх зорилгоор бүх төрлийн услах хэрэгслийг ашиглан усалгаа хийсэн талбайгаас хураасан ургацын хэмжээг үүнд хамруулна. Усалгааг тусгай зориулалтын услалтын систем, суваг, шуудуу, цистерн, хувин зэргийг ашиглан хийсэн байж болно. Усалгаатай талбайгаас хураасан ургацын дүнг нийт хураасан ургацын дүнгээс сугалж нөхнө. ***(Багана 3≥багана 5)***

**1-8 дугаар мөрөнд** үр тарианы ургацын хэмжээг асууж нөхнө. Үр тарианы ургацыг буудай, арвай, овьёос, хөх тариа, бог будаа, гурвалжин будаа, бусад гэсэн төрлөөр ангилан нөхнө. Малын тэжээлийн зориулалтаар тарьсан овьёос, гурвалжин будаа зэргийг үр тарианы хураасан ургацад оруулахгүй. ***(Мөр1=мөр(2:8))***

**9 дүгээр мөрөнд** төмсний ургацын хэмжээг нөхнө.

**2. Хүнсний ногоо, таримал мөөг, гоёл чимэглэлийн таримал:**Хүнсний ногоо, таримал мөөг, гоёл чимэглэлийн тармлын хэмжээг хураасан талбай, усалгаатай талбайгаас, нийт хураасан ургац, усалгаатай талбайгаас, хүлэмжээс гэсэн ангиллаар маягтын 10-36 дугаар мөрөнд өгөгдсөн нэр төрлөөр ялган нөхнө. Нийт хураасан ургацын дүнгээс усалгаатай талбай болон хүлэмжээс хураасан ургацын дүнг сугалж нөхнө.

**6 дугаар баганад** хүлэмжээс хураасан ургацыг асууж, нөхнө. Хүлэмжээс хураасан ургацын дүнг нийт хураасан ургацын дүнгээс сугалж нөхнө. ***(Багана 3≥багана 6)***

**10-32 дугаар мөрөнд** хүнсний ногооны ургацын хэмжээг нөхнө. Хүнсний ногооны ургацыг байцаа, лууван, шар манжин, улаан манжин, сонгино, саримс, өргөст хэмх, улаан лооль, тарвас, амтат гуа, хулуу, чинжүү, амтлагч ногоо, цэцэгт байцаа, брокколи, шанцай, цоохор майлз, бууцай, юуцай, хаш, бусад гэсэн төрлөөр ангилан нөхнө. ***(Мөр10=мөр(11:32))***

**24 дүгээр мөрөнд амтлагч** ногооны ургацын хэмжээг нөхнө. Амтлагч ногоонд яншуй, гоньд гэх мэт таримлууд орно.

**33 дугаар мөрөнд** таримал мөөгний ургацын хэмжээг нөхнө.

**34-37 дугаар мөрөнд** Цэцэг, гоёл чимэглэлийн хураасан ургацыг цэцгийн үр, цэцэг, бусад гэсэн ангиллаар нөхнө. ***(Мөр34=мөр(35:37))***

**3. Таримал тэжээл, техникийн ургамал, хадлан бэлтгэл:** Таримал тэжээл, техникийн ургамал, хадлан бэлтгэлийн хэмжээг нийт хураасан ургац, усалгаатай талбайгаас гэсэн ангиллаар маягтын 37-56 дугаар мөрөнд өгөгдсөн нэр төрлөөр ялган, нөхнө.

Үндэсний статистикийн хорооны даргын 2019 оны 12-р сарын 25-ны өдрийн А/190 дугаар тушаалын VII хавсралтаар батлав.

Монгол Улсын "Статистикийн тухай" хуулийн 22 дугаар зүйлийн 3 дугаар заалтыг үндэслэн мэдээллийн нууцыг хадгална.

**А-ХАА-8**

## УРГАЦ ХУРААЛТ, ХАДЛАН ТЭЖЭЭЛ БЭЛТГЭЛИЙН 20 … ОНЫ … САРЫН ЯВЦЫН МЭДЭЭ

**I. ХАЯГИЙН ХЭСЭГ**

| **1.Байршил** | Нэр | Код |
|---|---|---|
| Аймаг, нийслэл | | |
| Сум, дүүрэг□ | | |
| Баг, хороо | | |
| **2.Аж ахуйн нэгж, байгууллагын мэдээлэл** | | |
| Аж ахуйн нэгж, байгууллагын нэр | | |
| Регистрийн дугаар | | |
| Утасны дугаар | | |
| **3.Өрхийн мэдээлэл** | | |
| Өрхийн тэргүүлэгчийн овог, нэр | | |
| Өрхийн бүртгэлийн дэвтрийн дугаар | | |
| Утасны дугаар | | |

1. Баг/хорооны засаг дарга өрх, аж ахуйн нэгж, байгууллагаас мэдээг авч нэгтгэн, сум, дүүрэгт жил бүрийн 9, 10, 11 дүгээр сарын 01-ний дотор маягтаар ирүүлнэ.

2. Сумын статистикийн асуудал хариуцсан ажилтан, дүүргийн статистикийн хэлтэс 9, 10, 11 дүгээр сарын 02-ны дотор нийслэл, аймгийн статистикийн хэлтэст сум, дүүргийн нэгтгэлийг цахим шуудангаар дамжуулна.

3. Аймаг, нийслэлийн статистикийн газар, хэлтэс 9, 10, 11 дүгээр сарын 04-нд Үндэсний статистикийн хороонд цахим хэлбэрээр дамжуулна.

**II. УРГАЦ ХУРААЛТ**

**1. Үр тариа, төмс**

ТОННООР

| Үзүүлэлт | МД | Код | Хураасан талбай (га) | Усалгаатай талбай (га) | Хураасан ургац, бүгд | Ургацын хорогдол | Усалгаатай талбайгаас хураасан ургац |
|---|---|---|---|---|---|---|---|
| А | Б | В | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| **Үр тариа** *мөр1=мөр(2:8)* | 1 | 0110000 | | | | | |
| Буудай | 2 | 0111100 | | | | | |
| Арвай | 3 | 0115100 | | | | | |
| Овьёос | 4 | 0117100 | | | | | |
| Хөх тариа | 5 | 0116100 | | | | | |
| Бог будаа | 6 | 0118100 | | | | | |
| Гурвалжин будаа | 7 | 0119200 | | | | | |
| Бусад | 8 | 0119900 | | | | | |
| **Төмс** | 9 | 0151000 | | | | | |

**2. Хүнсний ногоо, таримал мөөг, цэцэг, гоёл чимэглэлийн таримал**

тонноор

| Үзүүлэлт | МД | Код | Хураасан талбай (га) | | Хураасан ургац, бүгд | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Усалгаатай талбай (га) | | Ургацын хорогдол | Усалгаатай талбайгаас хураасан ургац | Хүлэмжээс хураасан ургац |
| А | Б | В | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| **Хүнсний ногоо** *мөр10=мөр(11:32)* | 10 | 0120000 | | | | | | |
| Байцаа | 11 | 0121200 | | | | | | |
| Лууван | 12 | 0125111 | | | | | | |
| Шар манжин | 13 | 0125121 | | | | | | |
| Хүрэн манжин | 14 | 0125122 | | | | | | |
| Сонгино | 15 | 0125300 | | | | | | |
| Сармис | 16 | 0125200 | | | | | | |
| Өргөст хэмх (урт) | 17 | 0123211 | | | | | | |
| Өргөст хэмх (давжаа) | 18 | 0123212 | | | | | | |
| Улаан лооль | 19 | 0123400 | | | | | | |
| Тарвас | 20 | 0122100 | | | | | | |
| Амтат гуа | 21 | 0122900 | | | | | | |
| Хулуу | 22 | 0123500 | | | | | | |
| Чинжүү | 23 | 0123100 | | | | | | |
| Амтлагч ногоо | 24 | 0165400 | | | | | | |
| Цэцэгт байцаа | 25 | 0121310 | | | | | | |
| Брокколи | 26 | 0121320 | | | | | | |
| Салатны навч | 27 | 0121400 | | | | | | |
| Цоохор майлз | 28 | 0129001 | | | | | | |
| Бууцай | 29 | 0121500 | | | | | | |
| Юуцай | 30 | 0129002 | | | | | | |
| Хаш | 31 | 0123300 | | | | | | |
| Бусад | 32 | 0129000 | | | | | | |
| **Таримал мөөг** | 33 | 0127000 | | | | | | |
| **Цэцэг, гоёл чимэглэлийн таримал** ***мөр34=мөр(35:37)*** | 34 | 0196000 | | | | | | |
| Цэцэгийн үр | 35 | 0196300 | | | | | | |
| Цэцэг | 36 | 0196200 | | | | | | |
| Бусад | 37 | 0196900 | | | | | | |

**3. Таримал тэжээл, техникийн ургамал, хадлан бэлтгэл, бэлтгэсэн дарш, гар тэжээл, сүрэл, хужир шүү, эмийн ургамал, бусад**

тонноор

| Үзүүлэлт | МД | Код | Хураасан талбай (га) | | Хураасан ургац, бүгд | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Усалгаатай талбай (га) | | Ургацын хорогдол | Усалгаатай талбайгаас хураасан ургац |
| А | Б | В | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| **Таримал тэжээл** *мөр38=мөр(39+40+42+43)* | 38 | 0191000 | | | | | |
| Ногоон тэжээл | 39 | 0191900 | | | | | |
| Даршны ургамал | 40 | 0191921 | | | | | |
| Эрдэнэшиш | 41 | 0191100 | | | | | |
| Олон наст | 42 | 0191911 | | | | | |
| Бусад | 43 | 0191990 | | | | | |
| **Техникийн ургамал** *мөр44=мөр(45:48)* | 44 | 0140000 | | | | | |
| Рапс | 45 | 0144300 | | | | | |
| Чихрийн манжин | 46 | 0180100 | | | | | |
| Наранцэцэг | 47 | 0144500 | | | | | |
| Бусад | 48 | 0149900 | | | | | |
| **Бэлтгэсэн өвс** *мөр49=мөр(50+51)* | 49 | 0191931 | | | | | |
| Өөрсдийн бэлтгэсэн | 50 | 0191932 | | | | | |
| Худалдаж авсан | 51 | 0191933 | | | | | |
| **Бэлтгэсэн дарш** | 52 | 2331922 | | | | | |
| **Сүрэл** | 53 | 0191300 | | | | | |
| **Гар тэжээл** | 54 | 2331923 | | | | | |
| **Хужир шүү** | 55 | 1620091 | | | | | |
| **Эмийн ургамал** | 56 | 0193000 | | | | | |
| **Бусад** | 57 | 0199000 | | | | | |

ТАМГА

Тайлан гаргасан. . . . . . . . . . . . . . . . . . . . / /

Тайлан хянасан. . . . . . . . . . . . . . . . . . . . / /

20... оны ...-р сарын ...-ны өдөр

**38-43 дугаар мөрөнд** таримал тэжээлийн ургамлын ургацын хэмжээг асууж бүртгэнэ. Мал амьтныг тэжээх зориулалтаар тариалсан ургамлын ургацыг таримал тэжээлийн ургамлын ургацад хамруулна. Таримал тэжээлийн ургамлын хураасан ургацыг ногоон тэжээл, олон наст, даршны ургамал, бусад ургамлын хураасан ургац гэсэн төрлөөр ялган, бүртгэнэ. ***(Мөр38=мөр(39+40+42+43))***

**39 дүгээр мөрөнд** ногоон тэжээлийн ургацын хэмжээг асууж нөхнө. Ногоон тэжээлийн ургацад малын тэжээлийн зориулалтаар тарьсан овьёос, гурвалжин будаа зэргийн ургацыг хамруулан бүртгэнэ.

**40 дүгээр мөрөнд** даршны ургамлын ургацын хэмжээг асууж нөхнө. Даршны ургамлын ургацад малын тэжээлийн зориулалтаар тариалсан эрдэнэшиш, наранцэцэг зэрэг ургамлын ургацын хэмжээг хамруулна.

**41 дүгээр мөрөнд** даршны ургамлын ургацаас эрдэнэшишийн ургацыг ялган нөхнө**. *(Мөр40≥мөр41)***

**42 дугаар мөрөнд** олон наст ургамлын ургацыг хэмжээг асууж нөхнө. Тодорхой нэг жилд тариалаад 2 ба түүнээс дээш жилийн дараа үр жимс өгдөг олон наст ургамлын ургацыг үүнд хамруулан нөхнө.

**43 дугаар мөрөнд** дээрх ангилалд хамрагдаагүй бусад төрлийн таримал тэжээлийн ургамлын хураасан ургацын хэмжээг асууж нөхнө.

**44-48 дугаар мөрөнд** техникийн ургамлын ургацын хэмжээг асууж нөхнө. Үйлдвэрийн аргаар боловсруулан төрөл бүрийн бүтээгдэхүүн гарган авах зориулалтаар тариалсан техникийн ургамлын ургацыг үүнд хамруулна. Техникийн ургамлын ургацыг чихрийн манжин, рапс, наранцэцэг, бусад гэсэн төрлөөр ангилан нөхнө. ***(Мөр44=мөр(45:48))***

**47 дугаар мөрөнд** тос гаргаж авах зориулалтаар тариалсан наранцэцгийг оруулна. Дарш бэлтгэх зориулалтаар тариалсан наранцэцгийг оруулахгүй.

**48 дугаар мөрөнд** маягтад тусгагдаагүй бусад нэр төрлийн техникийн ургамлын ургацын хэмжээг асууж, нөхнө.

**49 дүгээр мөрөнд** бэлтгэсэн өвсний хэмжээг асууж бүртгэнэ. Бэлтгэсэн өвсөнд малын тэжээлд зориулж байгалиас гар болон механик аргаар хураан авсан ургамлыг хамруулна.

**52 дугаар мөрөнд** бэлтгэсэн даршны хэмжээг асууж нөхнө. Бэлтгэсэн дарш нь тусгай бэлтгэсэн сав, нүхэнд даршны ургамлыг давстай хольж даршилж бэлтгэсэн малын тэжээл юм.

**53 дугаар мөрөнд** бэлтгэсэн сүрлийн хэмжээг асууж нөхнө. Үр тарианы болон ургамлын үлдэгдэл иш, навчаар бэлтгэсэн малын тэжээлийн хэмжээг бэлтгэсэн сүрэлд хамруулан бүртгэнэ.

**54 дүгээр мөрөнд** бэлтгэсэн гар тэжээлийн хэмжээг асууж нөхнө. Байгалиас түүсэн өвс, ургамлаар бэлтгэсэн малын тэжээлийн хэмжээг гар тэжээлд хамруулна. Тухайлбал, зоодой, өвсөн мушгиа, таана, хөмүүлийн дарш гэх мэт.

**55 дугаар мөрөнд** бэлтгэсэн хужир, шүүний хэмжээг асууж бүртгэнэ. Хужир, шүүнд байгалиас хурааж, бэлтгэсэн давс, шүүг хамруулна.

**56 дугаар мөрөнд** эмийн ургамлын хураасан ургацын хэмжээг асууж нөхнө.

**57 дугаар мөрөнд** маягтад тусгагдаагүй бусад нэр төрлийн ургамлын ургацын хэмжээг асууж, нөхнө.

Хураасан ургацын хэмжээг тонноор илэрхийлэх бөгөөд өөрөөр илэрхийлсэн тохиолдолд маягтад доор итгэлцүүрийг ашиглан тоннд шилжүүлнэ.

**Шилжүүлэх итгэлцүүр:**

1 тонн = 1000 кг, 1000 гр= 1 кг

**Үндэсний статистикийн хороо**
**Эдийн засгийн статистикийн газар**
**Холбоо барих утас: 51-261565**

**38-43 дугаар мөрөнд** таримал тэжээлийн ургамлын ургацын хэмжээг асууж бүртгэнэ. Мал амьтныг тэжээх зориулалтаар тариалсан ургамлын ургацыг таримал тэжээлийн ургамлын ургацад хамруулна. Таримал тэжээлийн ургамлын хураасан ургацыг ногоон тэжээл, олон наст, даршны ургамал, бусад ургамлын хураасан ургац гэсэн төрлөөр ялган, бүртгэнэ. ***(Мөр38=мөр(39+40+42+43))***

**39 дүгээр мөрөнд** ногоон тэжээлийн ургацын хэмжээг асууж нөхнө. Ногоон тэжээлийн ургацад малын тэжээлийн зориулалтаар тарьсан овьёос, гурвалжин будаа зэргийн ургацыг хамруулан бүртгэнэ.

**40 дүгээр мөрөнд** даршны ургамлын ургацын хэмжээг асууж нөхнө. Даршны ургамлын ургацад малын тэжээлийн зориулалтаар тариалсан эрдэнэшиш, наранцэцэг зэрэг ургамлын ургацын хэмжээг хамруулна.

**41 дүгээр мөрөнд** даршны ургамлын ургацаас эрдэнэшишийн ургацыг ялган нөхнө**. *(Мөр40≥мөр41)***

**42 дугаар мөрөнд** олон наст ургамлын ургацыг хэмжээг асууж нөхнө. Тодорхой нэг жилд тариалаад 2 ба түүнээс дээш жилийн дараа үр жимс өгдөг олон наст ургамлын ургацыг үүнд хамруулан нөхнө.

**43 дугаар мөрөнд** дээрх ангилалд хамрагдаагүй бусад төрлийн таримал тэжээлийн ургамлын хураасан ургацын хэмжээг асууж нөхнө.

**44-48 дугаар мөрөнд** техникийн ургамлын ургацын хэмжээг асууж нөхнө. Үйлдвэрийн аргаар боловсруулан төрөл бүрийн бүтээгдэхүүн гарган авах зориулалтаар тариалсан техникийн ургамлын ургацыг үүнд хамруулна. Техникийн ургамлын ургацыг чихрийн манжин, рапс, наранцэцэг, бусад гэсэн төрлөөр ангилан нөхнө. ***(Мөр44=мөр(45:48))***

**47 дугаар мөрөнд** тос гаргаж авах зориулалтаар тариалсан наранцэцгийг оруулна. Дарш бэлтгэх зориулалтаар тариалсан наранцэцгийг оруулахгүй.

**48 дугаар мөрөнд** маягтад тусгагдаагүй бусад нэр төрлийн техникийн ургамлын ургацын хэмжээг асууж, нөхнө.

**49 дүгээр мөрөнд** бэлтгэсэн өвсний хэмжээг асууж бүртгэнэ. Бэлтгэсэн өвсөнд малын тэжээлд зориулж байгалиас гар болон механик аргаар хураан авсан ургамлыг хамруулна.

**52 дугаар мөрөнд** бэлтгэсэн даршны хэмжээг асууж нөхнө. Бэлтгэсэн дарш нь тусгай бэлтгэсэн сав, нүхэнд даршны ургамлыг давстай хольж даршилж бэлтгэсэн малын тэжээл юм.

**53 дугаар мөрөнд** бэлтгэсэн сүрлийн хэмжээг асууж нөхнө. Үр тарианы болон ургамлын үлдэгдэл иш, навчаар бэлтгэсэн малын тэжээлийн хэмжээг бэлтгэсэн сүрэлд хамруулан бүртгэнэ.

**54 дүгээр мөрөнд** бэлтгэсэн гар тэжээлийн хэмжээг асууж нөхнө. Байгалиас түүсэн өвс, ургамлаар бэлтгэсэн малын тэжээлийн хэмжээг гар тэжээлд хамруулна. Тухайлбал, зоодой, өвсөн мушгиа, таана, хөмүүлийн дарш гэх мэт.

**55 дугаар мөрөнд** бэлтгэсэн хужир, шүүний хэмжээг асууж бүртгэнэ. Хужир, шүүнд байгалиас хурааж, бэлтгэсэн давс, шүүг хамруулна.

**56 дугаар мөрөнд** эмийн ургамлын хураасан ургацын хэмжээг асууж нөхнө.

**57 дугаар мөрөнд** маягтад тусгагдаагүй бусад нэр төрлийн ургамлын ургацын хэмжээг асууж, нөхнө.

Хураасан ургацын хэмжээг тонноор илэрхийлэх бөгөөд өөрөөр илэрхийлсэн тохиолдолд маягтад доор итгэлцүүрийг ашиглан тоннд шилжүүлнэ.

**Шилжүүлэх итгэлцүүр:**

1 тонн = 1000 кг, 1000 гр= 1 кг

**Үндэсний статистикийн хороо**
**Эдийн засгийн статистикийн газар**
**Холбоо барих утас: 51-261565**